



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Далай ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол - Солонгосын хамтарсан "Монгол Саммок Ложистикс" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсугай. Үүнд:

Далайн захиргааны дарга

Зам, тээвэр хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын эдийн засаг, тариф хариуцсан мэргэжилтэн

Далайн захиргааны Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан албаны ахлах мэргэжилтэн

Далайн захиргааны Олон улсын гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

2. Хамтарсан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэчлэн томилогдсон Монголын талын бүрэлдэхүүний талаар хамтрагч БНСУ-ын талд мэдэгдэж холбогдох бүртгэлийг хийлгүүлэх арга хэмжээ авахыг Далайн захиргааны дарга /С.Түвшинтөр/-д үүрэг болгосугай.

3. "Монгол Саммок Ложистикс" ХХК-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 152 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

080080